



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 161

Даланзадгад

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийг нэгдүгээр, тус хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг хэрэгжилтийг удирдан зохион байгуулах комисст даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гарган, шаардагдах хөрөнгийг аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган, хэрэгжилтийн явц үр дүнг хөтөлбөрт заасан хугацааны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Бадраа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БАТЧУЛУУН



## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР.

/төсөл/

/ 2016 – 2023 он /

**Нэг.Түүхэн нөхцөл байдал.**

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн, цаашид ч уул уурхайн үйлдвэрлэлийн зэрэгцээ уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон зах зээлийн эрэлт, хэрэгцээ, хэрэглээнд тохирсон иж бүрэн үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Аймгийн мал аж ахуйн салбарын түүхэн хөгжлийн явцад тэмээ 1960 онд 194,5 мянга, адуу 1941 онд 176,5 мянга, үхэр 1939 онд 43,5 мянга, хонь 1940 онд 868,2 мянга, ямаа 2014 онд 1256,2 мянга тус тус тоолуулсан нь хамгийн дээд амжилт юм. Нийт мал сүргийн тоо толгой 1940 онд хамгийн их буюу 1,9 сая мал тоолуулж байсан бол 2014 онд 1849.0 мянган толгой мал тоолуулсан нь 75 жилийн өмнөх дээд амжилтандаа хамгийн ойртож ирсэн томоохон үр дүн болно.

2000-2003 онуудын дараалсан ган, зудын улмаас 907,3 мянга болон буурч, аймгийн хэмжээнд 700,0 мянган мал хорогдон, 520 өрх малгүй болж, 2009-2010 оны байгаль цаг уурын бэрхшээлээс өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч 2010 оны жилийн эцсийн байдлаар урьд оны нийт малын 35.2 хувь буюу 618.7 мянган толгой мал хорогдож, 461 малчин өрх малгүй болж, ажилгүйдэл ядуурал ихсэн орон нутгийн эдийн засаг болон малчдад ихээхэн хэмжээний хохирол учирсан нь нэг талаас отор нүүдэл, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэлийг дутуу хангах, мал маллагааны уламжлалт арга ухааныг дутуу эзэмших, ган - зуд, байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой хэдий ч нөгөө талаас уул уурхайн үйлдвэрлэлд хэт анхаарсан төрийн бодлого, бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг системтэй хөгжүүлэх эрх зүйн болон эдийн засгийн орчин цогц биш байсантай холбон тайлбарлаж болох талтай юм.

Иймд аймгийн нийт мал сүргийг эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөлжөө-бууц, худаг-уст цэгийг ариутган цэвэршүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, омог-хэвшлийг тодруулан бэхжүүлэх, бий болгох, үйлдвэрлэлийн гар ажиллагааг механикжуулах, хөнгөвчлөх, салбарыг бүхэлд нь эрчимжүүлэн хөгжүүлэх, мэргэжлийн байгууллага - мал эмнэлэг, үржлийн албаны бүтэц, тогтолцооны зохистой хэлбэрийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, санхүү, материаллаг бааз, боловсон хүчний чадвар, хүрэлцээ, хангамжийг бэхжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт ажиллах боломжит орчин, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, малчдын хамтын ажиллагаа-хүч хөдөлмөрөө хорших боломжийг бүрдүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.

### **Одоогийн нөхцөл байдал:**

**Нэг. Мал аж ахуй.** Аймгийн хэмжээгээр сүүлийн 4 жил дарааллан мал сүргээ 5 төрөл дээр өсгөж 2014 онд тэмээ 112741, адуу 66345, үхэр 16085, хонь 397600, ямаа 1256272 нийт 1849043 толгой мал сүргийг 5216 малчин өрхийн 9449 малчид адуулан маллаж, өсгөн үржүүлж байгаагаас 50 хүртэл малтай-424, 51-100 малтай-519, 101-200 малтай-1051, 201-500 малтай-2174, 501-999 малтай-859, 1000-1499 малтай-175, 1500-2000 малтай-10, 2000-аас дээш малтай-4 өрх тус тус байна.

Аймгийн 5216 малчин өрхөд 17949, 1555 мал бүхий өрхийн 5204 иргэн, 6771 өрхийн 23153 иргэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хамааралтай байгаа нь аймгийн хүн амын 38,8 хувийг эзэлж байна. Гэвч малчид, малчин өрхийн тоо 1993 онд 5430, 2000 онд 7044 байсантай харицуулахад 3.95-25.95 хувиар цөөрсөн үзүүлэлт төдийгүй удам залгаж малчин болох, залуу халаа нэмэгдэх байдал жил ирэх тутам буурч байгаа нь бодит зүйл болов. Өмнөговь аймаг нь төв Азийн цөлөрхөг хээр болох "Говь"-ийн бүс нутагт оршдог, байгаль цаг уурын хувьд зөвхөн бэлчээрийн мал аж ахуй эрхлэх боломжтой нутаг учир малчдад байгаль, цаг уурын энэ хүндрэлийг насан туршдаа бахархалтайгаар туулахын зэрэгцээ дараах бэрхшээлүүд тохиолдож байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах, амьдрах хүсэл, сонирхолыг бууруулж байна. Үүнд :

а/ Мал сүрэг хувьд шилжсэн үеээс амиа аргацаасан дан өрхийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн нь хамтран ажиллах, хөдөлмөрөө хорших, нэгдсэн зохион байгуулалтанд орох санал, санаачлага дутагдсанаас даяаршигдаж буй нөхцлийн өмнө хүч мөхөсдөн нийгмийн хөгжлийн хурдыг гүйцэхгүйд хүрснээр мэдээллийн зуунд өсөж бойжсон залуу үе мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах сонирхол буурсан.

б/ Уламжлалт бэлчээрийн мал маллагааны арга өөрчлөгдөж морь, тэмээгээр мал хариулахаа больсон, мотоцикль уналгын гол хэрэгсэл болсон байдал бэлчээрийг талхлах, хөрсийг сулруулахад зохих хэмжээгээр нөлөөлөн мал сүрэг тарга хүчээ бүрэн авахад бэрхшээл учруулснаас эргээд малчин хүний ажлыг хүндрүүлэх нэг нөхцлийг бүрдүүлсэн.

в/ Олон зуунуудыг дамжсан мал ноослох, услах арга ажиллагаанд өөрчлөлт ороогүй, гар хөдөлмөрөөр гүйцэтгэсэн хэвээр байгаа нь залуучуудыг бэрхшээх, малчны мэргэжлээс зайлсхийх бодолд хүргэсэн.

г/ Боловсролын системд орсон өөрчлөлтөөр суурь боловсролыг 6 настайгаас эхлэн эзэмшүүлэх болсон нь ээжүүд хүүхдээ харж суурин газар суух нэг нөхцлийг бүрдүүлж гэр бүлийн хоёр тусдаа амьдрах, үргүй зардал нэмэгдэх, хүч тарамдах, малын ашиг шим, бүтээгдэхүүнийг дутуу авах, зүй бусын хорогдол ихсэх зэрэг сөрөг нөлөөлөлөөс сум, аймгийн төв рүү шилжих хөдөлгөөн ихэссэн.

д/ Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, отор нүүдлийг зохион байгуулалт сайтай явуулах, худаг-уст цэгийг зөв эзэмшиж хамтран ашиглах, малын үүлдэр угсаа, ашиг шимийг төлөвлөгөөтэй сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, бууц-өвөлжөөгөө ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг урсгалаар явуулдаг зуршлаасаа салаагүй, үйл ажиллагаанд ахиц гараагүйгээс мал аж ахуйн үйлдвэрлэл хүндэрсэн.

е/ Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан инженерийн хийцтэй худаг, мал угаалгын суурин ванн эзэнгүйдсэн, хариуцлагын тогтолцоо байхгүй, хамтын хяналт тавидаггүй байдал нь эвдрэх, тоногдох байдалд хүргэж бэлчээрийн усан хангамжийн хүрсэн түвшингээс бууруулж байгаа нь бэлчээр талхлагдах, хомсдолд орох, малчны хөдөлмөр хүндрэх нөхцлийг бүрдүүлсэн.

ж/ Малчдын залуу халааг бэлтгэх, малчин мэргэжлийн олон төрлийн, хүнд бөгөөд бахархалтай хөдөлмөрийн онцлогийг өсвөр наснаас нь ойлгуулж түүнд дур сонирхолтой болгох төрийн болон орон нутгийн нэгдсэн бодлого дутагдахын зэрэгцээ залуу үеийг ажил, хөдөлмөрт шамдах чадвар төлөвшүүлэх тогтолцоо, ахмад үеээс суралцах, тэднээр бахархах, хүндлэх уламжлал хангалтгүй болсон.

Монгол орны нийт бэлчээрийн 65,0 хувь нь өөрчлөгдөж доройтсон, бэлчээрийн даац сэргээх чадавхийг зохицуулан ашиглавал хамгийн наанадаж 3 жилийн хугацаанд 40,0 хувь нөхөн сэргэх боломжтой, бэлчээрийн 7,0 хувь нь байгалийн аясаар эргэн сэргэх чадвараа бүрэн алдаж цөлжсөн гэсэн судалгаа байна. Бэлчээрийн 50,0 хувь нь үндсэн төлөв байдлаа бүрэн алдаагүй, одоогийн ашиглалтын хэлбэрийг үндсээр нь өөрчилж чадвал 10-н жилийн дотор сэргэн сайжрах боломжтой.

Бэлчээрийн доройтолд уур амьсгалын өөрчлөлт, хур тундасны багасалт, малын тооны ихсэлт, уул уурхай- зам- тээврийн хэрэгслийн хөдөлгөөн / механик хүчин зүйлс / , мал маллагааны уламжлалт аргад гарч буй өөрчлөлт зэрэг олон хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна.

Малын бэлчээр нь манай улсын стратегийн чухал ач холбогдолтой салбар, хүн амын хүнсний аюулгүй байдал, хөдөөгийн иргэдийн ажлын байр, орлогын эх үүсвэрт шууд хамаарна.

Нутаг - бэлчээр – усаа олсон нутагшсан малтай малчин хүн жаргадаг ардын сургаал байдаг бол аймгийн газар нутгийн 16,7 хувь, бэлчээрийн 24,3 хувь талхлагдах, усгүйдэх, хөрсний эвдрэл, тээврийн хэрэгсэл, технологийн нөлөөнд автах байдлаар хэвийн ашиглах боломжгүй болсон, 7-н сумын 1038,1 мянган га бэлчээр уул уурхай, барилгын үйлдвэрлэлийн явцад доройтож чанар, төлөв байдал нь муудсан, нийт бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн өөрчлөгдсөн, их талхлагдсан хэсэгтээ сэргэх боломжгүйд хүрсэн, хилийн боомт орчмын бэлчээр доройтолд автсан байдалтай болсны дотор Ханхонгор, Даланзадгад сумын бэлчээрийн 45,4, Цогт-Овоо сумын 41,4, Булган сумын 36,9 хувь талхлагдаад байна

Манай аймгийн бэлчээрийн жилийн дундаж нөөц 1405,8 мянган тонн, 3347,2 мянган хонин толгой мал багтаах даацтай, одоогийн байдлаар 2652,9 мянган хонин толгой мал бэлчээрлэж байгаа нь боломжийн үзүүлэлт шиг харагдаж байгаа ч нийт бэлчээрийн 42,7 хувь усжуулагдсан, ашиглалт багатай алслагдсан бэлчээр их талбайг эзэлдэг, бэлчээрийн 24,3 хувь талхлагдсан, төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан инженерийн хийцтэй 391 худаг ашиглалтгүй байгаагаас ихээхэн бэлчээр усгүй болсон зэргийг хасаж тооцвол ямар хэмжээний тэжээлийн нөөцтэй болсон нь тодорхой байна.

Үүссэн ноцтой нөхцөл байдалд эрүүл ухаанаар бодитой дүгнэлт хийж мал сүргийг тоогоор биш “чанар”-ыг эрхэмлэн бэлчээрийн нөхцөлд дасан зохицсон түргэн өсөлттэй малыг үржүүлэх, эх бүрээс төл бойжуулж зун-намрын бэлчээрээр тарга хүч авхуулан богино хугацаанд бордож зах зээлд залуу малын мах илүүтэй борлуулах замаар өвөл-хаврын тарчиг бэлчээрт байх малын тоог эдийн засгийн хохирол багатай цөөлөх, өнөөгийн байгаль - экологийн нөхцөлд тохирсон мал маллагааны дэвшилтэд аргыг бий болгож үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлж мөрдүүлэх шаардлагатай боллоо.

**2. Хөдөө аж ахуйн мэргэжлийн байгууллага:** Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн байгууллагын зохион байгуулалт нь дөрвөн хэлтэс, Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн нэгж бүхий 23-н орон тоотой, 15 сумын ЗДТГ-ын бүтцэд байдаг 2 мэргэжилтэнтэй, мал эмнэлэг, үржлийн тасагт 12 мал зүйч, 18 малын эмч, хувийн хэвшлийн мал үржлийн үйлчилгээний 1, мал эмнэлгийн үйлчилгээний 30 нэгж мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг малчдад үзүүлж, мал сүргийг халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, оношлох, эмчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч тухайн салбарт ажиллаж байгаа боловсон хүчний дундаж нас 47 байгаа нь мэргэжлийн ажил, үйлчилгээг цаашид авч хэрэгжүүлэхэд онцгой анхаарах зүй ёсны шаардлага тулгарч байна.

Эдгээр 31 нэгжийн 17 нь үйл ажиллагаагаа явуулах, вакцин, эм бэлдмэл хадгалах өөрийн байртай, 14 түрээсийн байр болон гэрээрээ, 21 нэгж дуудлага үйлчилгээний машинтай, 4 нэгж мотоциклтой, 6 нэгж өөрсдийн унаагүй, гэрээгээр болон түрээсийн унаагаар ажил үйлчилгээ гүйцэтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Тоног төхөөрөмжийн хувьд социализмын үед хэрэглэгдэж байсан багаж тоног төхөөрөмжүүдтэй, эдгээр багажууд нь стандартын шаардлага хангахаа байсан, ашиглах хугацаа дууссан. 2012 онд “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд хөргөгч, хөргүүр, дуудлагын иж бүрдэл, центрифуг, дээжийн хайрцаг, хөдөлмөр хамгааллын өвөл, зуны хувцас олгосон нь хамгийн сүүлд хийгдсэн хангалт байсан.

Мал хувийн өмчид шилжсэнээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулахаа байсан, мал эмнэлэг, мал үржлийн ажил үйлчилгээг үнэ төлбөргүй авч ирсэн социализмын үеийн сэтгэлгээнээсээ бүрэн салж чадахгүй байгаа, эмч, мэргэжилтний зөвлөгөөгүйгээр чанартай, чанаргүй эм бэлдмэл, хээлтүүлэгч малыг хувиараа авч хяналтгүй ашигладаг зэргээсмалын өвчлөл нэмэгдэх, малын чанараас илүү тоон өсөлтөд ач холбогдол өгөх хандлагатай болсон.

Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний үнэ хөлс хямд, зах зээлийн өргөн хэрэглээний бараа, бензин шатахууны үнийн өсөлт, дээр дурдсан үндэслэлүүдээс шалтгаалан мал эмнэлэг, үржлийн үйлчилгээ үзүүлдэг анхан шатны нэгжүүдэд ажиллах боловсон хүчингүй болж, санхүүгийн чадавх суларч, шаардлагатай тоног төхөөрөмжөө авч чадахгүй болсноор дампуурлын ирмэгт ирсэн.

Иймээс анхан шатны нэгжүүдийг ажлын байр, санхүүгийн хувьд бэхжүүлэх, боловсон хүчнийг шат дараатайгаар бэлтгэх, малчдын санал, санаачлагыг дээшлүүлэх дэс дараатай стратегийн бодлого хэрэгжүүлэх зэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна.

2014 оны байдлаар 200 хүртэл толгой малтай малчин өрх 38%-ийг эзэлж байгаа ч газар зүйн байршлын хувьд тархай бутархай байрласан цөөн малтай олон малчин өрх үйлдвэрлэл талаасаа ч, зах зээл талаасаа ч

ашигтай ажиллаж чадахгүй нь тодорхой, тэднийг хоршоо нөхөрлөлийн хэлбэрт шилжүүлэн нэгтгэхэд малчдын сэтгэхүй, сэтгэл зүйн бэлтгэл дутмаг, итгэлцэл байхгүй, хамтын хөдөлмөрийн давуу тал, хувийн зардлаа хэмнэх боломжийг бүрэн ойлгоогүй зэрэг бэрхшээлүүд байгаа тул тэдэнд явуулах сургалт, сурталчилгааны ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулах нь зүйтэй. Хөдөө аж ахуйн салбар нь бодит хэлбэрээр өсөн дэвжиж, бэлчээрийн мал аж ахуйг чанаржуулан хөгжүүлэх, тэнд үйлдвэрлэл эрхлэгчид нь зах зээлийн эрэлт хэрэгцээндээ тулгуурлан илүү өндөр ашиг шимтэй аж ахуйг эрхлэх байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үндэсний эдийн засгийн өсөлтөнд доривтой хувь нэмэр оруулахад хоршоо, нөхөрлөл, хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх асуудал чухал бөгөөд нутгийн мал сүргийг бэлчээрийн нөхцөлд зохицсон, түргэн өсөлттэй мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт омог, үүлдрийн малаар сайжруулан үржүүлэх, уст цэгийг түшиглэсэн эрчимжсэн жижиг аж ахуйг тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан эрхлэх зайлшгүй шаардлага байна.

**3. Хүнсний үйлдвэрлэл, хангамж:** Аймгийн хүнсний салбар хүн амын гол нэрийн хүнс мах, махан бүтээгдэхүүний 80,0, төмс, хүнсний ногооны 35,0-40,0 хувь, уламжлалт аргаар боловсруулсан сүү, цагаан идээгээр зуны улиралд 90,0 хувь хангаж байгаа ч хүйтний улиралд 4,0-5,0 хувь болж буурдаг. Аймгийн хэмжээнд талх, нарийн боовны цех 34, сүү, сүүн бүтээгдэхүүний жижиг болон өрхийн үйлдвэрлэл 13, цэвэр усны үйлдвэр 8, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 20, хүнсний дэлгүүр 338, барааны дэлгүүр 113, нийтийн хоол үйлдвэрлэл 110, худалдааны төв 14 үйл ажиллагаа явуулж энэ салбарт 1167 өрхийн 1739 хүн ажиллаж байна.

**4. Газар тариалан:** Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өнгөрсөн хугацаанд 319,0 га талбайн хүчин чадалтай 14-н услалтын систем баригдсаны 12 нь ашиглагдаж байгаа 110,0 га талбайн хүчин чадалтай 2 систем шинээр байгуулагдаад байна. Өнгөрсөн онд төмс 60,2, хүнсний ногоо 60,0, жимс, жимсгэнэ 20,45, тэжээлийн ургамал 40,0 нийт 180,7 га-д тариалан 1683.20 тн ургац хураан авсан. Хамгаалалттай хөрсний тариалан эрхлэхэд тодорхой ахиц гарч 145 хүлэмжийн 1838,0 м<sup>2</sup> талбайд 10-н төрлийн нарийн ногоо тариалж 60,4 тн ургац хураан авсан нь урьд оныхоос 37,0 хувиар нэмэгдсэн байна.

#### **Хоёр. Үндэслэл, шаардлага:**

"Монгол мал" үндэсний хөтөлбөр, "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр, "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль", Өмнөговь аймгийн "Малчин" хөтөлбөр, "Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-үүдийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг эрх зүйн нэгдсэн баримт болгон хэрэгжүүлэх шаардлага байна.

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн, цаашид ч уул уурхайн үйлдвэрлэлийн зэрэгцээ уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон зах зээлийн эрэлт, хэрэгцээ, хэрэглээнд тохирсон иж бүрэн үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Иймд аймгийн нийт мал сүргийг эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөлжөө-бууц, худаг-уст цэгийг ариутган цэвэршүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, омог-хэвшлийг тодруулан бэхжүүлэх, бий болгох, үйлдвэрлэлийн гар ажиллагааг механикжуулах, хөнгөвчлөх, ХАА-н салбарыг бүхэлд нь эрчимжүүлэн хөгжүүлэх, мэргэжлийн байгууллага - мал эмнэлэг, үржлийн албаны бүтэц, тогтолцооны зохистой хэлбэрийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, санхүү, материаллаг бааз, боловсон хүчний чадвар, хүрэлцээ, хангамжийг бэхжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт ажиллах боломжит орчин, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байгаа болно

Өмнөговь аймаг нь төв Азийн цөлөрхөг хээр болох "Говь"-ийн бүс нутагт оршдог, байгаль цаг уурын хувьд зөвхөн бэлчээрийн мал аж ахуй эрхлэх боломжтой нутаг учир малчдад байгалийн шалгарал, амьдралын их бэрхшээлийг даван туулах хүнд шалгуур тулгардаг. Говийн малчин хүн байгаль, цаг уурын энэ хүндрэлийг насан туршдаа сөрж туулахын зэрэгцээ дараах бэрхшээлүүд тохиолдож байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах, амьдрах хүсэл, сонирхолыг бууруулж байна. Үүнд :

а/ Мал сүрэг хувьд шилжсэн үеээс өнөөг хүртэл малчид амиа аргацаасан дан өрхийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн нь хамтран ажиллах, хөдөлмөрөө хорших, нэгдсэн зохион байгуулалтанд орох санал, санаачлага дутагдсанаас даяаршигдаж буй нөхцлийн өмнө хүч мөхөсдөн нийгмийн хөгжлийн хурдыг гүйцэхгүйд хүрснээр мэдээллийн зуунд өсөж бойжсон залуу үе мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах сонирхол багатай байна.

б/ Уламжлалт бэлчээрийн мал маллагааны арга өөрчлөгдөж морь, тэмээгээр мал хариулахаа больсон, мотоцикль уналгын гол хэрэгсэл болон өөрчлөгдөж байгаа байдал бэлчээрийг талхлах, хөрсийг сулруулахад нөлөөлөх, мал тарга хүчээ бүрэн авахад зохих хэмжээний бэрхшээл учруулснаас эргээд малчин хүний ажлыг хүндрүүлэх нэг нөхцлийг бүрдүүлсэн.

в/ Олон зуунуудыг дамжсан мал ноослох, услах арга ажиллагаанд өөрчлөлт ороогүй, гар хөдөлмөрөөр гүйцэтгэсэн хэвээр байгаа нь залуучуудыг бэрхшээх, малчны мэргэжлээс зайлсхийх бодолд хүргэсэн.

г/ Боловсролын системд орсон өөрчлөлт суурь боловсролыг 6 настайгаас эхлэн сургуульд суулган ээжүүд хүүхдээ харж суурин газар суух болсноор гэр бүлийн хоёр тусдаа амьдрах, үргүй зардал гарах, айл-өрхөд хүч тарамдах, малын ашиг шим, бүтээгдэхүүнийг дутуу авах, зүй бусын хорогдол ихсэх зэрэг сөрөг нөлөөлөлөөс сум, аймгийн төв рүү шилжих хөдөлгөөн нэмэгдсэн.

Үүссэн ноцтой нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийж мал сүргийг тоогоор биш "чанар"-ыг эрхэмлэн бэлчээрийн нөхцөлд дасан зохицсон түргэн өсөлттэй малыг үржүүлэх, зуны бэлчээрт байх малын тоог өсгөж

өвөл-хаврын тарчиг бэлчээрт байх малын тоог эдийн засгийн хохирол багатай цөөлөх, зах зээлд залуу малын мах илүү борлуулах боломжтой байх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

### **Гурав. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт.**

Аймгийн Өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагын баримтлах бодлого нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг дээшлүүлэх, байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах, хөрөнгө оруулалтаар бий болсон инженерийн хийцтэй худаг, усалтын системийн эзэмшилт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан үр өгөөжтэй ашиглах, хамгаалалттай хөрсний тариаланг хөгжүүлэх, хөдөө орон нутагт ХАА-н мэргэжилтнүүд, малчид тэдний гэр бүл, иргэд тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн сайжруулахад төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэхэд оршино.

**1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь** зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангах, нийгмийн шаардлагыг мэдэрч хөрвөх чадвартай хөгжих боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн, бүс нутагт хөдөө аж ахуйн салбарын эдийн засаг, бизнес, эрх зүйн таатай орчинг сайжруулан бэхжүүлэх, оролцогч талуудын үйл ажиллагааны чадавх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, малчид иргэдийн оролцоо, санаачлага, тогтвор суурьшилтай ажиллах хандлагад ахиц гаргах, эх нутагтаа үйлдвэрлэсэн экологийн цэвэр, чанартай, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг ханган хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэнэ.

**2. Хөтөлбөрийн зорилт нь** Хөдөө аж ахуйн салбарын нийт ажиллагсадын эрх зүйн орчин, санхүүгийн чадавх, материаллаг бааз, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх удирдлага зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх, түүнийг төгөлдөржүүлэх төр, иргэн, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нягт уялдуулан зохион байгуулахад оршино.

Аймгийн мал аж ахуй эрхэлдэг 54 багийг “Нэг баг–Нэг хоршоо–Нэг мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж” бүтэцрүү оруулан засаг захиргааны анхан шатны нэгжид харьяалагдах айл-өрх, иргэдийн оролцооны хүрээнд бүхий л асуудлаа хамтран шийддэг, тэнд шаардлагатай, цаг үеийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийг зохистой хэлбэрээр зах зээлийн зарчмын дагуу авч байх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд туслахад чиглэгдсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Мал сүргийн өсөж үржих үндсэн суурь болох бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах, усжуулах, отор нүүдлийг оновчтой зохион байгуулах, бий болсон инженерийн хийцтэй худгийг зөв эзэмшүүлж зохистой ашиглах, өвөл-хаврын бэлчээрийн ачаалалыг бууруулах, малчдын хүнд гар хөдөлмөрийг хөнгөвчлөх, механикжуулах, хөдөлмөрөө хорших, хамтран ажиллах, малчдын залгамж халааг бэлтгэх, тэднийг үр дүнтэй ажиллаж амьдрахад туслах, баг-нутаг усны асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг, түүнийг бүрэн хэрэгжүүлдэг бүтэц бий болгож үр дүнтэй дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хүнс, хөдөө аж ахуйн салбар нь зах зээлийн харилцаанд бүрэн шилжих бүтэц, зохион байгуулалт, хэрэглээнд тулгуурласан эрэлт, нийлүүлэлт, чанартай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, иновацийн хөгжил, мэдээлэл-үйл ажиллагааны сүлжээ бүхий оновчтой материаллаг баазын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

### **Дөрөв. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл.**

#### **1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх.**

1.1. Мал аж ахуйн салбарын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь мал сүргийг эрүүлжүүлэх, малын чанар, ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, байгаль, эдийн засаг, санхүү, хүний нөөцөө зохистой ашиглах, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, **зах зээлд** өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэн хүн амын хүнсний болон үйлдвэрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн **эрүүл** бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэх, мал аж ахуй, хүнсний салбарын тогтвортой хөгжлийг хангах.

1.2. Мал аж ахуйн салбарын ажил үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, фермерийн болон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах санаачилга, хөдөлгөөнийг дэмжих, Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн салбарыг бэхжүүлэхэд чиглүүлэх.

1.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, стратегийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл хангамжийг тогтвортой байлгах, мал аж ахуйн үйлдвэрлэлд лизингийн худалдаа, төлбөрт үйлчилгээг бий болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

1.4. МАА-н салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй хамтран ажиллах.

1.5. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг системтэй бэлтгэх, хоршоо бирж байгуулах, сүлжээ бий болгох, түүнчлэн хадгалах, тээвэрлэх, боловсруулах технологийг боловсронгуй болгох сав, баглаа боодлыг сайжруулах

#### **2. Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх.**

2.1. Мал сүргийг халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, мэргэжлийн бусад байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах, шаардлага гарсан тохиолдолд “Мал эмнэлгийн анги”-ийг дэлгэмэл байдлаар ажиллуулах бэлтгэл, зохион байгуулалт,

материаллаг бааз, хүн хүчний нөөцийг хангах, өвчний талаар нийт иргэдэд өргөн хүрээтэй мэдээлэл хүргэх, салбарын ажиллагсдыг тодорхой мэдлэгтэй болгох.

2.2. Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторид ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн багж тоног төхөөрөмжөөр хангах, дэвшилтэд арга зүй, стандарт нэвтрүүлэн үзлэг, оношлогоо, шинжилгээний чадавх, чанар, үр дүнг сайжруулах, мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хүртээмж, чанартай гүйцэтгэх.

2.3. Мал сүрэг, гэрийн тэжээвэр амьтныг гадны /эктопаразит/ болон дотрын /эндопаразит/ шимэгч хорхойн өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг нийт малыг хамруулан хийх, судалгаа туршилтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, шинжлэх ухааны байгууллагатай хамтарч ажиллах, тэргүүний ололт, шилдэг туршлагыг нэвтрүүлэх, малчдыг мэдлэг, мэдээллээр хангаж хамтарч үр дүнтэй ажиллах.

2.4. Халдварт болон гоц халдварт өвчин, зайлшгүй шаардлагатай дуудлагад шуурхай үйлчлэх, шалтгааныг тогтоох, бодит мэдээллийн дагуу тодорхой, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.5. Урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэх, угаах, туулгах, ариутгалын арга хэмжээний вакцин, эм бэлдмэл, бодисыг хугацаанд нь, шаардлагатай тоо, хэмжээгээр захиалах, авч нийлүүлэх, зарцуулалт, ашиглалтанд хяналт тавих, үр дүнг тооцох.

2.6. Уул уурхайн бүсийн малын эрүүл мэндэд нөлөөлөх тоосжилтыг багасгах, төв суурингийн ногоон байгууламжыг хамгаалахад орон нутагтай хамтарч ажиллах

### **3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг системтэй хөгжүүлэн бүтээмжийг нэмэгдүүлэх.**

3.1. Орон нутгийн хэмжээнд барьж байгуулсан услалтын системийн хүчин чадлыг бүрэн ашиглах, эзэмшүүлэх арга хэлбэрийг шинэчлэн сайжруулж дэвшилтэд технологи, ашиглаж нэгжийн ургацыг нэмэгдүүлэх, тогтвортой түвшинд барих

3.2. Говийн нөхцөлд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал тарих арчилах агротехник, ногоочны хариуцах талбайн үлгэрчилсэн хэмжээ, шаардлагатай багаж, техник хэрэгсэл, материал, үр, бордооны талаарх бүрэн хэмжээний гарын авлага, ном товхимолоор хангах, сургалт, мэдээллийг тогтмолжуулах.

3.3. Говийн үржил шим багатай, сул шороон хөрсийг хамгаалах, шар шуурганы хэмжээг бууруулах чиглэлээр “Хамгаалалттай хөрсний тариалан”-г хөгжүүлэх, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, амин дэмээр баялаг, олон төрлийн ногоогоор хүн амын хүнсний хэрэгцээг хангах, хангамжийг нэмэгдүүлэх

3.4. Нутагшсан болон шилмэл сортын үр, суулгац үржүүлэх, туршиж тариалах, гадаад дотоодын мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтарч ажиллах, төрөл бүрийн ногоо, жимс, жимсгэнэ тарих туршилтын талбайтай болох замаар “Газар тариалангийн технологийн төв” байгуулах, сонирхогчид, ногоочдод сургалт явуулах, дадлага хийлгэх, нутагшсан үр, суулгацаар хангах, газар тариалангийн бүх төрлийн техникийн үйлчилгээ үзүүлэх.

3.5. Зоорийн аж ахуйг хөгжүүлэх, шинээр механикжуулсан болон энгийн зоорь барих, ашиглах санаачлагыг дэмжих, хадгалалтын дэвшилтэд технологи нэвтрүүлэх, жишиг үнэ төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлэх байдлаар нутгийн хөрсөнд тарьсан ногоог хүн амд нийлүүлэх хугацааг уртасгах, ногоочдын орлогыг нэмэгдүүлэх.

### **4. Бэлчээр, усыг хамгаалах, зохистой ашиглах.**

4.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний сум, баг, хэсэг бүр бэлчээрийн байдалдаа сумын ЗДТГ-ын мэргэжилтний оролцоотой үнэлэлт өгөх, өвөл-хаварын бэлчээрийг хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, өнжөөх, сэлгэж ашиглах, бууц өвөлжөө, булаг-шандны эх болон орчмын бут, сөөг, голын /нутгийн хэллэгээр/ бэлчээрийг хашиж нөөцлөн шаардлагатай үед ашиглах, сум бүр бэлчээр ашиглалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах.

4.2. Ургамалын гарц, өнтэй жилийн бэлчээрийн ургацыг ашиглан хадлан тэжээлийг санаачлагатай бэлтгэх, ядарч доройтоход амархан өсвөр болон эх мал, шинэ төлийг нэмэгдлээр тэжээх нутгийн чанартай өвс, хадлан, хужир, долооцыг нөөцлөх, аймаг, сум бүр аюулгүйн нөөцтэй байх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, зохистой хадгалж хамгаалах, хорогдолгүй борлуулах арга хэмжээ авах.

4.3. Улс, орон нутгийн төсөв, төсөл-хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар баригдсан инженерийн хийцтэй худгийг зохистой эзэмшүүлэх, усалгааны хөлсийг тогтоон мөрдөх, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, эвдрэлтэй 400 шахам худгийн шалтгааныг тогтоож засварлах, хохирол давтан гаргуулахгүй байх.

4.4. Нийт бэлчээрийн 42,7 хувь усжуулагдсан 80,0 хувьд хүргэхэд 3315,7 мянган га бэлчээр усжуулах шаардлагатай бөгөөд үүнд 664 худаг шинээр гаргах тооцоог үндэслэн усжуулалтын ажлыг зохион байгуулах, усжуулах шаардлагатай бэлчээрийн гүний усны нөхцлийг үнэлэхэд 50,0 хувь ус агуулах хурдацтай учир хайгуулийг өргөн хүрээнд хийх.

4.5. Талхлагдсан, их хэмжээний доройтолд орсоноос ургамалын бүрэлдэхүүн өөрчлөгдөж шим тэжээлтэй ургамлын зүйл, төрөл хомсдсон зарим газрын бэлчээрт бороо угтуулан олон настын үр цацаж турших, хашсан бэлчээрийг сайжруулах, булаг-шандын усыг халиаж чийгний хангамжийг нэмэгдүүлэх.

4.6. Сум бүр отрын нөөц бэлчээртэй болох,

### **5. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэгцээнд үндэслэсэн хэрэглээ, хангамжийг сайжруулах.**

- 5.1. Мал аж ахуйн гаралтай малын мах, сүү, экологийн цэвэр орчинд ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тээвэрлэх, хадгалах, дэвшилтэд технологиор боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, технологийн тогтвортой байдлыг хангах, лабораторийн шинжилгээнд хамруулан баталгаажуулах.
- 5.2. Өмнөговь брендийг бий болгох, үйлдвэрлэх, нэр - төрөл, чанар, тоо – хэмжээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сурталчилах, зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх.
- 5.3. Сум бүр бренд бүтээгдэхүүнээ тодорхойлох, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хүргэн зах зээлтэй болох.
- 5.4. Экологийн цэвэр /органик/ бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, цех байгуулах боломжтой гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүд мэдээлэл хүргүүлэх, хамтрах санал гаргах, үйлдвэрлэл эрхлэгчдийн үүсэл, санаачлагыг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах.
- 5.5. Бог малыг нядлах механикжсан үйлдвэрийн шугам шинээр ашиглалтанд оруулах, сум, суурин газрыг түшиглэсэн хээрийн мал нядалгааны цэг, газрууд байгуулан бэлчээрийн малын махыг экологийн цэвэр бүтээгдэхүүн хэвээр ашиглах боломжийг бүрдүүлэх, орон нутгийн хэрэгцээг хангах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох нөхцлийг хангах, бий болсон үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглах,
- 5.6. Нийтийн хоол, сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн цай-хоол, ундны усны чанарыг стандартын шаардлагад нийцүүлэх, технологи, эрүүл ахуйн тогтвортой байдал, хүнсний салбарт ажиллагсад соёлтой, баталгаатай, чанартай үйлчилгээний дадал эзэмшүүлэх.
- 5.7. Мах, төмс, хүнсний ногооны нөөц бүрдүүлэх санхүүгийн дэмжлэгийг шалгуур давсан аж ахуйн нэгжид олгох, хавар, зуны улиралын хүн амын хэрэгцээг тогтвортой үнэд хязгаарлагдсан бүтээгдэхүүнээр хангах, интервенц зохион байгуулах.
- 5.8. Орон нутгийн махны үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулан малчдын малын махыг боловсруулах, экспортлох бодлого боловсруулах, зохицуулалт бий болгох, хилийн боомтоор мах экспортлох зөвшөөрөлтэй болгох

## **6. Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах.**

- 6.1. Малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хоршоо, эрчимжсэн мал аж ахуйг дэмжин хөгжүүлэх, хамтын хөдөлмөрийн давуу тал, үр нөлөө, цар хүрээг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг тогтвортой, бодит түвшинд байлган амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, эмчилгээ, сувилалд хамруулах.
- 6.2. Үйлдвэрлэлдээ шилдэг үүлдэр, омгоор мал сүргээ сайжруулсан, ашиг шимийг нэмэгдүүлж бүрэн ашигласан, малыг эрүүлжүүлэх, халдваргүйжүүлэх, угаалга, туулгалт, хот бууц, худгийн ариутгалыг хугацаанд нь бүрэн, чанартай хэрэгжүүлдэг, үр бүтээл, тогтвор суурьшилтай ажилладаг, нутаг орондоо нэр хүндтэй малчдыг алдаршуулах, төрийн гавьяа, шагналд хамруулах, арга туршлагыг нийтэд түгээх
- 6.3. Малчдын залуу халаа–залуу малчид, зорилтод бүлгийн айл өрх /200 хүртэл малтай/-ийг малжуулах, ахуйн нөхцөл, ажиллах баталгааг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мал маллагааны арга, туршлага, шинжлэх ухааны ололт, дэвшилтэд технологи, тэргүүний техник, тоног төхөөрөмжийн талаар мэдээлэл, мэдлэг олгох.
- 6.4. Малд нүдтэй, дур сонирхолтой, эцэг-эх нь дэмжсэн хүүхдийг мал аж ахуйн үйлдвэрлэл, малын дэргэд байлгаж насан туршийн боловсролд хамруулах.
- 6.5. Мал аж ахуйн хүнд, гар хөдөлмөрийг хөнгөвчлөх, механикжуулах, малчдад техник хэрэгсэл ашиглах дадлага эзэмшүүлэх, мал маллагааны уламжлалт арга, уналга, эдэлгээ, саалинд сургах, сүү, цагаан идээ бэлтгэх, мал ахуйн тоног хэрэгслийг гэрийн нөхцөлд үйлдвэрлэх хичээл, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр малчидад хүргэх, сургалтанд хамруулах, гэрчилгээ олгох.
- 6.6. Ногоо, жимс жимсгэнэ тарих сонирхолтой иргэд, ногоочдод “Газар тариалангийн технологийн төв”-өөр бүрэн сургалт өгөх, дадлагажуулах, талбайд нь арга зүйн туслалцаа үзүүлэх, гадаад дотоодын туршлага судлуулах, төсөлд хамруулах байдлаар мэдлэг, чадварыг сайжруулж орлогыг нэмэгдүүлэх, тэргүүний арга туршлагыг сурталчлах, алдаршуулах.
- 6.7. Мал аж ахуйн мэргэжилтнийг төлөвлөгөөтэй бэлтгэх, гэрээгээр суралцуулах, тэтгэлэгт хамруулах, ажлын гарааны нөхцлийн дэмжлэг үзүүлэх, дадлага эзэмшүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоо /систем/ бий болгох.
- 6.8. Мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бусад материалыг стандартын дагуу хангах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, анхан шатны нэгжид олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа мэргэжилтэнд урамшил олгох боломжийг судлах.
- 6.9. Мал аж ахуйн багт “Мал эмнэлэг, үржлийн ажлын үйлчилгээний нэгж”-ийг шинээр байгуулсан, мэргэжил эзэмшин хувийн нэгж ажиллуулах малын их эмч, мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологич нарыг Монгол улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрдлээр хангаж ажиллах нөхцлийг бүрдүүлэх.

## **7. Материаллаг баазыг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах.**

- 7.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийг хөнгөвчлөх. Тэмээ, хонины ноосыг цахилгаан агергатаар хяргах хайч, дагалдах хэрэгслийг МЭҮТасаг цаашдаа Малчдын хоршоо, МЭҮНэгжийг түшиглэн олгох, инженерийн хийцтэй худгийн ус өргөх төхөөрөмжөөр хангах, зохистой эзэмшүүлэх,
- 7.2. Малчдын өдөр тутмын болон ахуйн хэрэглээнд зайлшгүй шаардлагатай нар, салхины цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй гэрэлтүүлэг, гар чийдэн, хотны гэрэлтүүлэг, телевизор, хөргөгч, радио, тээврийн хэрэгслийг нийлүүлэгч хуулийн этгээдтэй хамтран ажиллах, үнэ, чанар, үйлчилгээгээр өрсөлдөх боломж бүрдүүлэх

7.3. Мал сүргийг паразит өвчнөөс хамгаалах, халдваргүйжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, угаалгын суурин ванн, зохиомол хээлтүүлэгийн пунктээр хангах, засварлах, усжуулагдаагүй бэлчээрт усны хайгуул хийх, инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худгийг төлөвлөгөөтэйгээр гаргах.

7.4. Ноос, ноолуур угаах, самнах, ялгах, бөмбөлгөн ноос, утас ээрэх, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр, цех шинээр байгуулах, бий болсон хүчин чадлыг ашиглах санал, санаачлагыг дэмжих, төсөл, зээлд хамруулах, гадаад, дотоодын хуулийн этгээдэд зуучлах.

7.5. Мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өвөл, хаврын бэлчээрийн дарамт, талхагдлыг бууруулах, өсвөр малыг нядлах зорилтын хүрээнд “Бог мал нядлах” механикжсан шугамыг барилга, байгууламжийн хамт барьж ашиглалтанд оруулах, сумдын бүсчлэл, малын тоо, нутагшлалаар “Мал бордох” талбай, хээрийн мал нядалгааны газар байгуулах.

7.6. Мал аж ахуйтай багийг “Нэг баг–нэг малчны хоршоо–нэг МЭҮАҮНэгж” гэсэн системд шилжсэн хамт олонд Монгол улсын стандарт MNS-1-2011. MNS-2-2011. MNS-3-2011-д заагдсан хөрөнгийн дэмжлэг үзүүлэх, автомашиныг хөнгөлөлттэй болон эргэн төлөгдөх нөхцлөөр олгох, ноос хяргах хэсэг байгуулж цахилгаан аяагатаар хангах, бэлчээр усжуулах, ус өргөх төхөөрөмжийг эхний ээлжинд нийлүүлэх.

7.7. Сумдын МЭҮТасаг, аймгийн ХХААГазрын материаллаг бааз, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг эдэлгээний норм, хэрэглээний шаардлага, ашиглалтын хугацаа, хөгжлийн хандлагыг харгалзан хангалт хийх, шинэчлэх замаар бэхжүүлэх.

7.8. Аймгийн “Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатор”-ийг хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, нийлүүлэлтийн чанарт хүртээмжтэй хяналт тавих, шаардлагатай шинжилгээ судалгааг орчин үеийн түвшинд дэвшилтэд арга зүй, стандартаар явуулах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжыг бүрдүүлсэн хянан баталгаа хийдэг болоход шаардлагатай тоног төхөөрөмж, багж хэрэгсэл, эм урвалж, стандартаар хангах, ашиглалтын хугацаа дууссан лабораторийн барилгыг шинээр барих, хүчин чадлыг өргөтгөх.

7.9. Малын халдварт болон олон толгойгоор өвчилсөн, яаралтай тусламжын үйлчилгээ үзүүлэх дуудлагын автомашин, угаалга-ариутгал-туулгалт, мал эмнэлгийн шуурхай үйлчилгээ үзүүлэх тусгай зориулалтын орчин үеийн тээврийн хэрэгсэл нийлүүлэх, “Гоц халдварт өвчин” гарахад мал эмнэлгийн ангийг дэлгэмэл байдлаар ажиллахад шаардлагатай хэрэгсэл, материал, тоног төхөөрөмжөөр хангах.

7.10 Газар тариалан эрхлэгчдийг 25-35 морины хүчтэй трактор /дагалдах хэрэгслийн хамт/, чанар сайтай хүлэмжийн материал бүхий үнэ өртөг багатай хүлэмж, үр, бордоо, бусад шинэ техник, тоног төхөөрөмжөөр тариаланчдыг хангах.

#### **Тав. Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат:**

Аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил”-ийн хөтөлбөрийг 2016-2019 он, 2020-2023 он гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх ба аймгийн “Малчдын зөвлөгөөнийг хоёр жил дутамд хийж байх цаг хугацаатай явцын үр дүнг тодорхой гаргаж зөвлөгөөний төлөөлөгчдөд тайлагнах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх, оролцогчдын санал, дүгнэлт, ажлын явц, үр дүн, хүрсэн түвшин, хөрөнгө санхүүгийн боломж, нөхцөл, гадаад дотоодын төслийн хамралт, улс хоорондын шууд харилцаа, түншлэлийн бололцоонд тулгуурлан тодотгох, шинэчлэн сайжруулна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн дагуу Улс, аймаг, сумдын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв болон энэ салбарт явуулах төсөл, арга хэмжээнд тодорхой тусгаж гүйцэтгэлийг зохион байгуулна.

Хөгжлийн хөтөлбөрийг хариуцан зохицуулах Ажлын хэсгийг аймгийн ЗДТГазрын санал болгосноор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан бүрэлдэхүүн, ХХААГазар, сумдын ЗДТГазартай хамтран бусад мэргэжлийн байгууллага /агентлаг/-ын орлооойгоор хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хоёр жилийн явцын үр дүнг ХХААГазар хариуцан гаргаж холбогдох газруудад хүргүүлэх, 2017, 2019, 2021, 2023 оны “Малчдын зөвлөгөөн”-д танилцуулах, дөрвөн жилийн нэгдсэн тайланг 2019, 2023 онуудад гаргаж аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Ажлын явц, гарч байгаа үр дүн, хүрсэн түвшинг нийтэд мэдээлэх, ололтыг бататгах, дутагдлыг арилгах, бэрхшээлийг даван туулах арга замыг жилийн ажлын гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийж тодорхойлон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр дүгнэлт, санал гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудал оруулан шийдвэрлүүлнэ.

#### **Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр.**

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд :

1. Улс / аймаг /-ын төсвийн хөрөнгө.
2. “Оюу толгой” төслийн хамтын ажиллагааны төслийн санхүүжилт
3. Аймгийн “Хөгжлийн сан”-гийн хөрөнгө.
4. Аймаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө.
5. Улсын төсвөөс бүрддэг сангийн хөрөнгө оруулалт.
6. Хандивлагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тусламж.
7. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт.
8. Салбарт оруулсан санхүүжилтээс эргэн төлөгдсөн хөрөнгийн эх үүсвэр.



Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг жилийн санхүүжилтын эх үүсвэр нь Аймгийн тухайн жилийн орлогын 1,0 хувиас дээш хэсэг оролцсон бусад дээрх санхүүжилтээс бүрдэх хэмжээ буюу 3,8-4,2 тэрбум төгрөгөөс доошгүй байна.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР.

### ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ 2016 – 2023 он /төсөл/

№	Стратегийн тэргүүлэх зорилтууд	Дэд зорилтууд	Хэрэгжүүлэх арга зам
1	Тэргүүлэх зорилт 1: Малын чанар, үүлдэр сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх	1.1 Мал үржлийн ажил үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц чанарыг сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадварын дээшлүүлэх	<p>1.1.1. Мал үржлийн ажил үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөжүүлж анхан шатны нэгжийг бэхжүүлэх</p> <p>1.1.2. Баталгаажсан үүлдэр омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, баталгаажсан малыг сайжруулагчаар ашиглах, өсвөр хээлтүүлэгч бэлтгэх</p> <p>1.1.3. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ангид ялган суурилж, ашиг шим, үржлийн бүртгэл хөтлөх, шилмэл хээлтүүлэгчдийг шалгаруулах суртачлах</p> <p>1.1.4. Зах зээлийн эрэлт хэрэгцээ, цаг уурын өөрчлөлтөд тулгуурлан төрөл хоорондын болон сүргийн оновчтой бүтцийг бий болгох</p>
1.2 Шинжлэх ухааны ололтыг мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх		<p>1.2.1. Өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, явуулын үйлчилгээг хөгжүүлэх, аймгийн төвд үр хадгалах, зохиомол хээлтүүлгийн лабораторитой болох</p> <p>1.2.2. Малчин өрхийн эдийн засгийн сонирхол дээр тулгуурлан түргэн өсөлттэй малын аж ахуйг хөгжүүлэх</p> <p>1.2.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээнд нийцэх дэвшилтэт технологийг өргөнөөр нэвтрүүлэх /нар салхины эрчим хүчээр ажилладаг тоног төхөөрөмжүүд, цахилгаан хайч, автомат саалтуур г.м/</p>	
1.3 Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон эрсдэл даах чадвартай мал аж ахуйг хөгжүүлэх замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулах		<p>1.3.1. Газар тариаланд түшиглэсэн малын тэжээл хийх цех байгуулах</p> <p>1.3.2. Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон өндөр ашиг шимт нэг төрлийн мал дагнан үржүүлэх, хагас суурин аж ахуй, мал бордох аж ахуйг хөгжүүлнэ.</p> <p>1.3.3. Малын бүртгэлийн системийг сайжруулах замаар нийт цөм сүрэг, хээлтүүлэгч малыг нэгдсэн бүртгэлд оруулна.</p>	
1.4 Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэл,		1.4.1 Мал аж ахуйг эдийн засгийн эргэлтэд оруулах	

